

**"Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд хийсэн ажлын биелэлт**

2023 оны 12 сарын 28- ны өдөр

Улаанбаатар хот

№	Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ажил арга хэмжээ	Хариуцах нэгж	Хугацаа	Биелэлт
<b>Нэг: Албан хаагчдын ажлын нөхцлийг сайжруулах талаар :</b>				
1	Албан хаагчдыг бичгийн хэрэгсэл, хөгжмийн запас сэлбэгээр хангах	Санхүү	жилийн турш	Чавхдаст морин хуур хөгжмийн хялгас, сатурк, давирхай, шанз, ёочин, ятга хөгжмийн иж бүрдэл утас, цохиур зэрэг, мөн бишгүүр, эвэр бүрээ, их хуур хөгжмийн хулс зэрэг сэлбэгийг Хан-мюзик ХХК, Эгшиглэн магнай ХХК-тай хамтран ажиллах замаар тасралтгүй хангалт хийж, хөгжимчдийн хөгжмийн зэмсгийн сэлбэгээр хангаж ажилласан. Монгол үндэсний найрал хөгжмийн стандартад бүрэн нийцсэн хийц загварын өндөр түвшний ардын үндэсний хөгжмийн зэмсэг болох морин хуур 4, ятга 3, шанз 1, эвэр бүрээ 1 ширхэгийг нийт 9 хөгжмийн зэмсэг, бусад хөгжмийн зэмсгийн запас сэлбэгийн зардалд нийт 31.500.000 төгрөгийг зарцуулсан.
2	Заалны гэрэл, гэрэлтүүлгийг сайжруулах	Санхүү, тайз үйлдвэрлэлийн ангийн дарга	жилийн турш	Албан хаагчдын хөдөлмөрлөх нөхцлийг сайжруулах замаар тайзны хэсэгт 100 гаруй ширхэг гэрэл, оффис болон уран бүтээлчдийн өрөө тасалгааны гэрэлтүүлгийн тасалдал доголдлыг тухай бүр арилгаж ажилласан.
3	Өрөө тасалгааны дулаан, чийгшил, гэрэлтүүлгийн нөхцөлийг сайжруулах ажил зохион байгуулах	ХАБЭА хариуцсан мэргэжилтэн, ХНМ	жилийн турш	Ялангуяа хурлын өрөөний гэрэлтүүлэг муудаж сэлбэгийн олдоц муудсан тул тасалгааны гэрэлтүүлгийн төхөөрөмжийг шинэчилж гэрэлтүүлгийг хэвийн хэмжээнд болгож, стандарт хангасан. Бүжигчдийн бэлтгэлийн өрөөний гэрэлтүүлгийг сэлбэж 30 гаруй гэрлийг солив. Мөн оффисын хэсэгт байрлах 202 тоот өрөө тасалгааны хувьд хэт том байснаар суугаа ажилтай албан хаагчдад тав тухгүй байдал олон жил үргэлжилсэнийг таслан зогсоож, өрөөг дундуур нь тасалж захиргааны болон уран бүтээлийн удирдлагыг тэгш хуваарилан байршуулснаар өрөө тасалгааны дулаан нэмэгдэж тав тухтай ажиллах нөхцөл бүрдсэн.
4	Тайз, техникийн ажилчдыг нормын хувцас, ажлын хувцсаар хангаж өгөх	Санхүү	II-III улирал	Тайз техникийн ажилчдыг ажлын хувцсаар хангахаар хувцасны зураг төслийг гаргаж театрын даргаар батлуулсан. Төсвийн хэмнэлтийн тухай хуульд заасны дагуу театрын төсөвт энэхүү зардалд зарцуулах хөрөнгө байхгүй тул удаашрах хандлагатай байна. Гэхдээ, тайз техникийн ажилчдыг өдөр тутам ажлын бээлий, багаж тоног төхөөрөмжөөр тасралтгүй хангаж ажилласан.
5	Уран бүтээлчдийг шинэ хувцсаар хангах, тоглолтын хувцасны угаалга үйлчилгээг тогтмолжуулах	Захиргаа, уран сайхны зөвлөл	жилийн турш	Уран бүтээлчдийн тоглолтын хувцсыг "Нарта" хими цэвэрлэгээний газартай хамтран ажиллаж байнгын цэвэрлэгээ үйлчилгээг хийж ажилласан. Уран бүтээлчдийн нийт 290 гаруй хувцсыг тоглолтын ачааллыг харгалзан цэвэрлэгээ үйлчилгээ, нөхөн сэргээлтийн ажлыг зохион байгуулав. Мөн шинээр Дэлхийн мод төслийн 18 ширхэг хувцас, Огторгуйн хангал бүжгийн 1, Мөнх-Алдар бүжгийн 1, Хөх шувуу бүжгийн 1 хувцсыг шинээр хийлгэсэн.

Хоёр: Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах талаар :				
6	Ажлын үр дүн, мэргэшлийн үр чадварын түвшинг үнэлж дүгнэх, үр дүнгийн шагнал, урамшуулал олгох	Захиргаа, уран сайхны зөвлөл	улирал тутам	Театрын цалин хөлсний журамд заасны дагуу одоо ажиллаж байгаа 69 албан хаагчаас 43 албан хаагчид үр чадварын нэмэгдлийг сар бүр олгож, сард 9,765,807 төгрөгийг, хагас жилээр ажлын үр дүнг үнэлж дүгнэн 32 Албан хаагчид 33,153,546 төгрөгийг, сүүлийн хагас жилийн ажлыг дүгнэж 49 ажилтанд нийт 57,441,122 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон.
7	Албан хаагчдад хоол, унааны мөнгийг төсвийн хүрээнд тогтмол олгох	Захиргааны зөвлөл	жилийн турш	Театрын Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу 63 албан хаагчид өдрийн хоолны хөнгөлөлтийг хүн тус бүрт 10000 төгрөгөөр, 59 албан хаагчид нийтийн тээврийн хөнгөлөлтийг хүн тус бүрт 500 төгрөгөөр тооцон сар бүр олгов.
8	1 удаагийн буцалтгүй тусламжийг шаардлагатай албан хаагчид олгох	Захиргааны зөвлөл	жилийн турш	Театрын Хөдөлмөрийн Дотоод журамд тусгасны дагуу ар гэрт нь гачигдал гарсан 3, хүнд хэлбэрийн өвчтэй болон өртөг өртөгтэй мэс заслын эмчилгээ хийлгэсэн 2, нийт 5 албан хаагчид байгууллагын хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу нэг удаагийн буцалтгүй тусламж олгов. Тусламжаар олгосон мөнгөн дүн 2.050.000 төгрөг.
9	Албан хаагчдын дунд амьдралын нөхцөл байдлын судалгаа явуулж, шаардлагатай албан хаагчдад тусламж дэмжлэг үзүүлэх асуудлаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх	Захиргаа, ХНМ	байнгын	Албан хаагчдын нийгмийн байдлыг тодорхойлох судалгааг 2023 оны 10 сарын 15-наас 11 сарын 01-ны хооронд GOOGLE FORM хэлбэрээр явуулсан. Үүнд 49 албан хаагч оролцлоо. Үүнд: Захиргаанаас 9, Хөгжим ангиас 18, Дуу ангиас 7, Бүжиг ангиас 8, Тайз үйлдвэрлэлийн ангиас 6, хүүхэд асрах чөлөөтэй байгаа 1 албан хаагч судалгаанд хамрагдсан байна. Судалгаанд оролцоогүй гэрээт буюу давхар ажил эрхэлдэг 7 албан хаагч, судалгаанд оролцох ёстой тодорхойгүй шалтгаанаар судалгаа бөглөөгүй 13 албан хаагч байна. Гоцлол дуучин Г.Хонгорзул, Гоцлол дуучин С.Ганзориг, Нярав Д.Дэлхийцэцэг, Тасалбар шалгагч Ю.Хулан, О.Түвшинжаргал, Тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Ц.Батцэнгэл, ХАБЭА хариуцсан мэргэжилтэн Б.Бүрэнжаргал, Менежер Р.Мөнхсайхан, Их хуур хөгжимчин Г.Бат-Өлзий, Бүжигчин Ч.Мэндсайхан, Тайзны машинист Р.Сийлэгмаа, Гэрэлтүүлэгч Д.Батмөнх, Морин хуур хөгжимчин А.Мөнгөн нар судалгаанд оролцоогүй байна. Давхардуулж судалгаа бөглөсөн 3 тохиолдол гарсан байна. Тус 3 үр дүнг хасаж нэгтгэв. Судалгаанд оролцогсад ам бүлийн хувьд 1-8 хүний хамт амьдарч байна. Үүнээс ганцаараа амьдардаг 4, хамгийн олуулаа буюу 8-уулаа амьдардаг 1 албан хаагч байна. Дундаж наслалт 35.2. Боловсролын хувьд бакалавр 24, магистр 10, докторант 1, бүрэн дунд боловсролтой 2, тусгай дунд боловсролтой 2. Судалгаанд оролцсон 49 албан хаагчийн 36 нь өөрийн гэсэн орон сууцтай болох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Байгууллагын зүгээс анхаарч үзэх шаардлагатай байгаа албан хаагчдын тоонд 8 албан хаагчийг авч үзлээ. Олон ам бүлтэй хашаа байшинд амьдардаг 1, монгол гэрт амьдарч байгаа 2, Улаанбаатар театр олон жил тогтвор суурьшилтай ажилласан болон хүндэтгэн үзүүштэй албан хаагчдынхаа амьдралд дэм болохуйц тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна гэж дүгнэлээ.
10	Төр, засгийн болон Нийслэлийн шагналд албан хаагчдыг тодорхойлох	Захиргааны зөвлөл	тэмдэглэлт өдрүүдээр	Соёл урлагийг хөгжүүлэх үйл хэрэгт оруулсан хувь нэмрийг үнэлж, 12 албан хаагчийг төр засгийн одон медалиар шагнуулахаар тодорхойлноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын Урлагийн Гавьяат зүтгэлтэн цолоор 2, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Алтан гадас одонгоор 3, Соёлын Яамны Жуух бичигээр -1, Соёлын тэргүүний ажилтан цол тэмдгээр 1 албан хаагч шагнуулаад байна.

11	Мэргэжлийн уралдаанд оролцох уран бүтээлчдэд бодитой дэмжлэг үзүүлэх, тэднийг урамшуулах	Уран сайхны зөвлөл	жилийн турш	Улсын болон олон улсын хэмжээний мэргэжлийн уралдаанд театрын уран бүтээлчид ур чадвараа сорьж оролцсоор ирсэн. Үүний үр дүнд уран бүтээлчдийн чансаа дээшилж, мэргэжлийн хувьд салбартаа танигдан манлайлан ажиллах боломж нээгддэг. 2023 оны хувьд 10 уран бүтээлч мэргэжлийн өндөр шалгуур бүхий уралдаанд амжилттай оролцлоо. Театрын хувьд энэхүү уралдаанд оролцож байгаа уран бүтээлчдээ бүх талаар дэмжиж ажилласан. Тэдний амжилтаас дурдвал, Бүжигчин Г.Энхжаргал Хэнтий аймагт зохион байгуулагдсан МУУГЗ, бүжиг дэглээч А.Санжаасүрэнгийн нэрэмжит Гоцлол бүжигчдийн улсын уралдаанаас Гуравдугаар байр, Гоцлол хөгжимчин Б.Мягмарцэрэн Монгол Улсын Төрийн дээд шагнал Чингис хаан одонт, Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Урлагийн гавьяат зүтгэлтэн, хөгжмийн зохиолч Бямбасүрэнгийн Шаравын нэрэмжит "Мэргэжлийн дуучид, үндэсний хөгжимчдийн олон улсын гуравдугаар уралдаан"-ы Мэргэжлийн хөгжимчин төрөлд "Хоёрдугаар байр", Гоцлол дуучин О.Анхчимэг Дорнод аймагт болсон Уртын дуу дуулаачдын улсын уралдаанд Тэргүүн байр, "Монголын үн хамт амьдарч байна. Үүнээс ганцаараа амьдардаг 4, хамгийн олуулаа буюу 8-уулаа амьдардаг 1 албан хаагч байна. Дундаж наслалт 35.2. Боловсролын хувьд бакалавр 24, магистр 10, докторант 1, бүрэн дунд боловсролтой 2, тусгай дунд боловсролтой 2. Судалгаанд оролцсон 49 албан хаагчийн 36 нь өөрийн гэсэн орон сууцтай болох хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн байна. Байгууллагын зүгээс анхаарч үзэх шаардлагатай байгаа албан хаагчдын тоонд 8 албан хаагчийг авч үзлээ. Олон ам бүлтэй хашаа байшинд амьдардаг 1, монгол гэрт амьдарч байгаа 2, Улаанбаатар театр олон жил тогтвор суурьшилтай ажилласан болон хүндэтгэн үзүүштэй албан хаагчдынхаа амьдралд дэм болохуйц тодорхой ажлуудыг зохион байгуулах шаардлагатай байна гэж дүгнэлээ. тус тус эзэлсэн байна. Энэхүү уран бүтээлчдээ театрын захиргаа, удирдлагын зүгээс тодорхой хэмжээнд урамшуулж, зарим уран бүтээлчдийн төрийн одон медалиар шагнуулахаар тодорхойлсон.
12	Оны хөдөлмөрийн аварга, шилдэг ажилчдыг шалгаруулж шагнаж урамшуулах.	Захиргаа, уран сайхны зөвлөл	12 сард	2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөр Захиргаа, уран сайхны зөвлөлийн өргөтгөсөн хурлаар анги тус бүрээс театрын шилдэг ажилтанд нэр дэвшүүлэх албан хаагчдын асуудлыг авч хэлэлцэв. Дуу ангиас Гоцлол дуучин О.Анхчимэг, Гоцлол дуучин Т.Баянжаргал, хөгжим ангиас Гоцлол хөгжимчин Б.Мягмарцэрэн, бүжиг ангиас Гоцлол бүжигчин Б.Норовбанзад, тайз үйлдвэрлэлийн ангиас Гэрэлтүүлэгч Б.Оюунгэрэлийн нэрийг дэвшүүлснийг хэлэлцэн Оны шилдэг ажилтнаар Гэрэлтүүлэгч Б.Оюунгэрэлийг шалгаруулж 300.000 төгрөгөөр шагнаж урамшуулав.
13	Хүүхдийн баяр болон шинэ жилийн баяраар албан хаагчдын хүүхдүүдэд бэлэг өгөх	Захиргааны зөвлөл	5, 12 сар	Мөн жил бүрийн 6 дугаар сарын 1-нд болдог Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр буюу Хүүхдийн баяраар театрын албан хаагчдын 95 хүүхдэд Ханбүргэдэй их дэлгүүрийн хүүхдийн бэлгээр албан хаагчдынхаа хүүхдүүдэд бэлэг барьсан. Тус үйл ажиллагаанд зориулагдсан 3.027.463 төгрөгийн зардлыг театрын даргын тушаалаар, зохих журмын дагуу байгууллагын төсвөөс гаргаж санхүүжүүлсэн. Мөн жилийн эцсээр шинэ жилийн баярыг тохиолдуулан "Талх чихэр" ХК-тай хамтран ажиллаж, нийт албан хаагчдадаа баярын бялуу бэлэг болгон өгсөн.
<b>Гурав: Албан хаагчдын амралт сувилал, эрүүл мэндийг сахин хамгаалах талаар :</b>				
14	Нийслэлийн байгууллагуудын Спорт наадамд оролцох	Хамт олноороо	III улирал	Нийслэлийн Захирагчийн албанаас зохион байгуулсан нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын СПОРТ НААДАМ-д Улаанбаатар театрын хамт олон ажлын байрны дасгал, дартс, сагс, волейболын тэмцээнд багаа бэлтгэн оролцож, Ажлын байрны дасгалаар нийслэлд 1-р байр, шигшээ тэмцээнд 2-р байр эзэлсэн.

15	"Эрүүл агаар эм" өдөрлөгийн үйл ажиллагаа зохион байгуулах	Дуу анги	II улирал	"Эрүүл агаар эм" өдөрлөгийн үйл ажиллагааг Дуу ангийн хамт олон 2023 оны 10 дугаар сард Тэрэлжид амралтын газарт зохион байгуулав. Энэ өдөрлөгийн үеэр шар барилдаан, эмэгтэй сумо, үндэсний бөх, АХА тэмцээнийг зохион байгуулж, тэмцээнд амжилттай оролцсон анги, албан хаагчдыг урамшуулав.
16	Хамт олноороо хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, ажлын байран дээрээ дасгал хөдөлгөөн хийж хэвших	Бүжиг анги	жилийн турш	Бүжиг ангийн санаачлагаар бүжгийн дасгалын танхимд өдөр бүр албан хаагчдад зориулсан иога, сунгалтын дасгалыг бүжгийн багш Д.Баярт удирдан ажиллуулдаг. Мөн албан хаагчдад зориулсан Ажлын байрны дасгалыг нийт албан хаагчдын дунд 7 хоногийн 3 өдөр зохион байгуулж, албан хаагчдыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх ажилд туслалцаа үзүүлж ажилладаг.
17	"Эрүүл амьдарцгаая" сэдвийн хүрээнд албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмч нарын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах	ХАБЭА хариуцсан мэргэжилтэн, ХНМ	II-III улирал	Эрүүл мэндийн Яамнаас хэрэгжүүлж байгаа иргэдийн эрүүл мэндийг сахин хамгаалах хөтөлбөр "Эрт илрүүлэг"-т орох 22 албан хаагчийг ажлаас чөлөөлж, зохицуулалт хийж ажилласан. Мөн 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр батлуулсан "Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2023 оны хийх ажлын төлөвлөгөө"-нд тусгасны дагуу 29 албан хаагчийг цус, шээс, биохимийн шинжилгээнд хамруулах ажлыг Сонгинохайрхан дүүргийн "Арвин мэнд" өрхийн эмнэлэгтэй хамтран зохион байгуулсан. Тус шинжилгээгээр эмгэг өөрчлөлт илэрсэн албан хаагч байхгүй. Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нэгдсэн эрүүл мэндийн төв эмнэлэгтэй хамтран Эрүүл мэндийн сайдын 2014 оны 10 дугаар сарын 20 ны өдрийн 340 дугаар тушаал, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн 14- дүгээр зүйлийн 14,1 дэх хэсэг удирдлага болгон нийт албан хаагчдыг эрүүл мэндийн хугацаат үзлэгт 2023 оны 11 дүгээр сарын 07, 08, 09 ны өдрүүдэд бүрэн хамруулж ажилласан.


Тайлан бичсэн:

Хүний нөөцийн менежер

 Л.Одгэрэл

Хянасан :

Захиргааны ахлах мэргэжилтэн

 Б.Түмэндэлгэр

УЛААНБААТАР ТЕАТР

9021120651  
5097401 ▲ ХНТ5524  
УЛААНБААТАР ХОТ